

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

АБА 613:525.7.011.4

Анги Т 58

Байгаль орчныг хамгаалах. Агаар мандал, Агаарыг бохирдуулах бодисыг тодорхойлох аргад тавих ерөнхий шаардлага. Охрана природы. Атмосфера. Общие требования к методам определения загрязняющих веществ	MNS 3113 - 81 СТ СЭВ 3598-80
--	---------------------------------

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн Үнэ, стандартын улсын хорооны 1981 оны 124-р тогтоолын дагуу 1982 оны 1-р сарын 1-нээс 1987 оны 1-р сарын 1-ний өдөр хүртэл мөрдөнө.

Ерөнхий шаардлага

1. Зохих журмын дагуу авч бэлтгэсэн сорьцонд шинжилгээ хийнэ.
2. Агаар мандлыг бохирдуулах бодисыг тодорхойлох арга нь шинжилгээнд авсан сорьцонд тухайн бохирдуулах бодис нь түүний зөвшөөрөгдөх дээд концентрацийн 0,8 буюу түүнээс бага хэмжээний байхад уг бодисын агуулгыг сонгон тодорхойлох боломжийг хангах ёстой.
3. Шинжилгээний аргын нарийвчлал нь (сорьц авахыг оролцуулан) хэмжигдэж байгаа концентрацын бүх цараад $\pm 25\%$ -иас хэтрэхгүй байвал зохино.
4. Шинжилгээний арга нь бохирдуулах бодисыг бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд концентрацийн 0,8-аас 10 хүртэлх хязгаар зохих нарийвчлалтай хэмжих боломжтой байвал зохино.
5. Шинжилгээний арга нь агаар мандлын найрлаганд тогтмол байж, ихэвчлэн тохиолдох хорт бодис жишээлбэл: жигнэгдэгч бодис түүнчлэн CO_2 , H_2O ба хамссан бодисууд байхад тодорхойлолтыг явуулахад хамгийн сонгомол арга байвал зохино.
6. Хэрэв тодорхойлохоос өмнө химийн ямар нэг урвал явагдах бол үүссэн бодис нь бохирдуулах бодисыг тодорхойлох бүх хугацаанд тогтвортой (үл өөрчлөгдөх) байх ёстой. Энэ хугацааг тодорхойлох аргын агуулгад оруулсан байвал зохино.
7. Шинжилгээг явуулахад хэмжлийн зөвшөөрөгдөх нарийвчлалыг хангаж чадах багаж хэрэгсэл, II ангиас доошгүй нарийвчлалтай сав суулга, тухайн шаардлагыг хангахуйц цэвэр урвалжийг хэрэглэнэ. Агаар мандалд байгаа бохирдуулах бодисыг тодорхойлох аргыг бичих зарчмыг мэдээллийн хавсралтын дагуу бүрдүүлнэ.

Урвалжийг хэрэглэхэд болон тодорхойлолтын явцад урьдчилан эрүүл мэндэд хортой болон аюултай бодис үүсэх үед авах урьдчилан сэргийлэх бүх арга хэмжээг зааж оруулсан байх ёстой.

Шингээгч байгууламж багаж хэрэгслийн бохирдуулагч бодисын шингээлтийн бүтээмж нь 95%-иас багагүй байвал зохино.

Мэдээллийн хавсралт

Агаарт байгаа бохирдуулах бодисыг тодорхойлох аргын агуулгад:

Агаарыг бохирдуулах бодисын физик химийн шинж чанар, томьёо (молекул жин, үнэр, ус болон органик уусгагчид уусах байдал, буцлах температур, ханасан уурын даралт, концентраци, агрегатын байдал, токсикологийн товч шинж, ЗДК гэх мэт).

- аргын зарим тодорхойлолт;
- тодорхойлох явцыг саатуулагч нөлөө;
- хэрэглэх урвалжийн жагсаалт, тэдгээрийн анги хэрэглэх уусмалын жагсаалт, тэдгээрийг бэлтгэх, хэрэглэх журам, хадгалах нөхцөл, хугацаа;
- хэрэглэх аппарат багаж хэрэгсэл;
- сорьц авах нөхцөл;
- шинжилгээнд авсан агаарын сорьцыг хадгалах, тээвэрлэх, нөхцөл;
- шинжилгээ хийх нөхцөл;
- тохируулах график байгуулах журам;
- тодорхойлолтын нарийвчлал;
- үр дүнг боловсруулах;
- шинжилгээний дүнд үүссэн бодисыг хоргүй болгох аргыг тус тус тусгана.

ТӨГСӨВ.